

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2016 оны 06 сарын 06

/Хяналтанд авсан заалтаар/


Д/д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Хувь
1	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр авлигын эсрэг хийж байгаа ажлын талаар мэдээлэл хийх.	Байгууллагын дотоод сургалтын цаг дээр бүх албан хаагч нарт “Авлигаас хэрхэн урьдчилан сэргийлэх” тухай сургалтыг зохион байгуулж, Авлигагүй хамт олон уриаг дэвшүүлж, цахим хуудас болон орон нутгийн телевизэд 1 удаа мэдээлэл хийсэн.	100
2	Байгууллагын удирдлага нийт албан хаагчдын хурал, зөвөлгөөн дээр авлигын эсрэг яриа таниулга хийж байх.	Газрын хурлыг 14 хоног тутам, хэлтсийн хурлыг 7 хоног хийдэг. Сар бүр газрын хурал дээр авлигын эсрэг яриа, таниулгыг 3 удаа хийсэн.	100
3	Шинээр гарсан хууль бусад шийдвэрийн төслүүдийг байгууллагын цахим хуудаст байршуулж, иргэдийн саналыг авах боломжийг бүрдүүлэх.	Шинээр батлагдсан хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль, гадаад паспортын шинэ журмыг иргэдэд таниулах зорилгоор цахим хуудаст байршуулсан. Иргэдээс 2 санал ирсэн.	100
4	Улсын бүртгэл, статистикийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийн жагсаалтыг өөрийн цахим хуудсанд байршуулах.	Эд хөрөнгийн бүртгэл, Иргэний бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээний төрлийг тодорхой бичиж www.govisumber.ubseg.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн Статистикийн үйл ажиллагаатай хууль тогтоомж, мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж ирсэн.	100
5	Бүртгэл хөтлөх журам, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг байгууллагын цахим хуудаст байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах.	Эд хөрөнгийн бүртгэл, Иргэний бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээний бүрдүүлэх материал, үнэ, тариф, хугацааг тодорхой бичиж www.govisumber.ubseg.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн Статистикийн үйл ажиллагаатай хууль тогтоомж, мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж ирсэн.	100
6	Үйлчилгээний шат дамжлагыг багасгах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг судлах, нэвтрүүлэх.	Сүмбэр сумын иргэний бүртгэлийн үйлчилгээг онлайнд холбосон. Иргэний үнэмлэх шинээр авах, сунгуулах иргэдийн ИУБ-31 маягтын мэдээллийг онлайнаар	100


		дамжуулж эхэлсэн. Ингэснээр иргэний үнэмлэхний хэвлэгдэж ирэх хугацаа багасч, 14 хоногт ирэх боломжтой болсон. Газар шинээр өмчилж авч байгаа иргэдийн өргөдлийг гараар бичүүлж авдаг байсныг болиулж, тусгай маягт бөглүүлж, үйлчлүүлэгчийн цаг хугацааг хэмнэдэг болсон.	
7	Бүртгэлийн хууль, дүрэм журмыг олон нийтэд сурталчилах, иргэдийн эрх зүйн албан бус сургалтыг зохион байгуулах.	2016 оны 03 сарын 30-нд зөрчилтэй албан хаагчдын зөрчлийг арилгах зорилгоор “Иргэдэд үйлчлэх өдөрлөг” – ийг зохион байгуулсан. Өдөрлөгөөр эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээний төрөл үнэ, тариф, хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын зүйл заалтаар иргэдэд хичээл зааж, сонирхсон асуултад хариулт өгсөн.	100
8	Шинэ томилогдсон төрийн албан хаагч бүрийг ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьтай танилцуулж, мөрдүүлэх.	Улсын бүртгэлийн байгууллага, Статистикийн байгууллагатай нэгдэж, шинэ бүтэц орон тоогоор ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан бүх албан хаагч нарын ажлын байрны тодорхойлолт өөрчлөгдөн батлагдаж ирснийг бүх албан хаагч нарт танилцуулсан.	100
	Хариуцсан ажил үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаар нээлттэй болгох.	Албан хаагчдын мэдээлэл, хариуцах албан тушаалын чиглэлийг байгууллагын www.govisumber.ubseg.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	100
9	УБСГазрын иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжтэй байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх хэрэглэгчийн үнэлгээг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх.	7 хоног бүр иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг авч хэвшсэн. Ирсэн санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. 11 сард иргэний нийгмийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээг хийлгэхээр төлөвлөөд байна.	70
10	Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн ажлын тайланг байгууллагын цахим хуудсаар мэдээлсэн байх.	3-р улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Хугацаа болоогүй байна.	
11	УБСЕГ-ын шинэчлэн баталсан ёс зүйн дүрмийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, албан хаагч нарт танилцуулах. Ёс зүйн зөрчил илэрсэн тохиолдолд хуульд	Улсын бүртгэл, Статистикийн байгууллага нэгдсэнээс хойш ёс зүйн дүрэм шинэчлэн батлагдаагүй байна. Ёс зүйн зөрчил одоогоор илрээгүй болно.	70

	заасан хариуцлагыг хүлээлгэж, хамт олонд мэдээлэх.		
12	Хэлтэс бүрт үйл ажиллагаа, албан хаагчдын ёс зүйн байдлын талаарх санал хүсэлтийг хүлээн авах утас болон санал хүсэлтийн хайрцаг байршуулах, түүний хэрэгжилтийг тайлагнах.	Бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч нарын үйлчилгээ үзүүлсэн албан хаагчийн үйлчилгээний соёл, ёс зүйн байдлын талаар өдөр тутам санал хүсэлтийн хуудас бөглүүлэн, 7 хоног бүрийн хурал дээр санал хүсэлтийг авч хэлэлцдэг. 70543306 дугаарын иргэдэд зөвлөх утсыг ажиллуулж байна. Одоогоор гомдол ирээгүй болно.	100
13	Газар, хэлтсээс гарч буй шийдвэрийг ил тод нээлттэй байдлыг хангах, нөхцөл боломжийг бүрдүүлэх.	Газраас гарч буй санхүүгийн болон бусад шийдвэрийг байгууллагын ил тодын самбар болон www.govisumber.ubseg.gov.mn болон facebook хуудаст байршуулж ирсэн.	100
14	Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр хураамжийн талаарх мэдээллийг өөрчлөлт орсон тухай бүр нь мэдээллийн хэрэгслээр болон самбарт байршуулах.	Энэ онд иргэний бүртгэлийн үйлчилгээний үнэ, төлбөр, хураамжид өөрчлөлт ороогүй болно. Одоо мөрдөгдөж байгаа үнэ тарифыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан.	100
15	Иргэний, Эд хөрөнгийн, Хуулийн этгээдийн бүртгэлийн болон статистикийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг байгууллагын цахим хуудсанд байршуулах.	Эд хөрөнгийн бүртгэл, Иргэний бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, үнэ тарифыг www.govisumber.ubseg.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн Статистикийн үйл ажиллагаатай хууль тогтоомж, мэдээ, мэдээллийг байнгын тогтмол байршуулж ирсэн.	100
16	УБСЕГ-ын хуулиар тогтоосон эрхлэх асуудлын талаар болон байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах.	Сонгуулийн тухай хуулийн өөрийн байгууллагад хамааралтай зарим зүйл заалтыг олон нийтэд суртчилан таниулсан. Үүнд: Шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсох тухай, сонгогч шилжих тухай заруудыг орон нутгийн телевиз радиогоор мэдээлсэн. Мөн ААНБ-ын тооллогыг 2016 оны 04 сарын 1-нээс 5 сарын 1-ны хооронд явуулах тухай мэдээлэл, зарыг иргэдэд хүргэсэн. Нийт 9 удаа хэвлэл, мэдээллээр суртчилсан.	100
17	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг амаар, бичгээр, цахим хэлбэрээр болон утас,	2016 оны эхний хагас жилийн байдлаар тус газар нь 33 өргөдөл санал хүсэлт, 1 гомдол хүлээн авч, 29 өргөдөл, 1	

	хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факсаар хүлээн авч шийдвэрлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх.	гомдлыг зохих хууль журмын дагуу шийдвэрлэсэн байна.Шийдвэрлэсэн шатандаа байгаа 4 өргөдлийг холбогдох мэргэжилтэнд шилжүүлээд байна. Иргэдийн өргөдөл, гомдол санал хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг байгууллагын www.govisumber.ubseg.gov.mn цахим хуудаст тогтмол байршуулан ажиллаж байна.	100
18	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар байгууллагын цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх.	Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг амаар болон цаасан хэлбэрээр, цахим хуудасны зочны дэвтэр, 70543306 утсанд тогтмол авч шийдвэрлэн ажиллаж байна. Байгууллагын www.govisumber.ubseg.gov.mn цахим хаягаар иргэдийн өргөдөл гомдол санал хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр тогтмол тавьж, иргэдэд хүргэн ажиллаж байна.	100
19	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлэх арга хэмжээ зохион байгуулах.	Тус газарт одоогоор авлигатай тэмцэх газар болон холбогдох газраас зөвлөмж ирээгүй болно.	100
20	АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийг биелүүлэх, арга хэмжээ зохион байгуулах.	Тус газарт одоогоор авлигын шинжтэй гэмт хэрэг гараагүй. Мөн мэдэгдэл ирээгүй болно.	100
21	Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг цаг хугацаандаа хэрэгжүүлж ажиллах.	УБСЕГазрын гаргасан авлигын эсрэг үйл ажиллагааны эсрэг төлөвлөгөөний дагуу төлөвлөгөө боловсруулан батлуулж, заасан хугацаандаа хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70
22	Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 сарын 15-ны дотор АТГ-т хүргүүлэх.	Хугацаанд нь хүргүүлнэ.	
23	Авлигын эсрэг төрийн болон ТББ, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилгад нэгдэх.	Хуулийн байгууллагын удирдах ажилтны ээлжит уулзалтыг 2016 оны 03 сарын 11 өдөр тус газар зохион байгуулсан. Уулзалтад 5 байгууллагын дарга удирдлагууд оролцсон. Уулзалтаар тус газар нь 2 байгууллага нэгдсэн тухай танилцуулга, төрийн албан хаагч авлигаас хэрхэн ангид байх тухай, сонгуулийн хуулийн талаар хэлэлцэж,	100

		гаргасан саналд нэгдсэн.	
24	Байгууллагын удирдах албан тушаалтнууд /Газар, хэлтсийн дарга нар/ авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлаа илэрхийлж нэгээс доошгүй ажил шинээр санаачилж зохион байгуулах.	Хугацааг 3-р улиралд явуулахаар төлөвлөөд байна. Хугацаа болоогүй байна.	

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  3.БАЯНДУГАР

ТАНИЛЦСАН:
 УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗРЫН
 ДАРГА  Л.ЦЭЛМЭГ

